



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 07 сарын 08 өдөр

Дугаар 4/893

Улаанбаатар хот

Барилга акталж, данснаас
хасах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1.2 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйл, 78 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалт, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны “Барилга акталж, нийслэлийн өмчийн бүртгэлээс хасах тухай” 58 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 58 дугаар тогтоолын дагуу Нийслэлийн ерөнхий боловсролын 7 дугаар сургуулийн балансад бүртгэлтэй, нийт 186,423,325.79 (нэг зуун наян зургаан сая дөрвөн зуун хорин гурван мянга гурван зуун хорин таван төгрөг далан есөн мөнгө) төгрөгийн бүртгэлийн үнэ, 112,596,390.41 (нэг зуун арван хоёр сая таван зуун ерэн зургаан мянга гурван зуун ерэн төгрөг дөчин нэгэн мөнгө) төгрөгийн үлдэх өртөг бүхий хавсралтад дурдсан барилгыг акталж, данс бүртгэлээс хасахыг Нийслэлийн ерөнхий боловсролын 7 дугаар сургууль (Д.Дашдорж)-д зөвшөөрсүгэй.

2.Барилгын хоёрдогч түүхий эдийн зориулалтаар дахин ашиглах боломжтой эд хөрөнгийг худалдан борлуулж 1,360,500.00 (нэг сая гурван зуун жаран мянга таван зуун) төгрөгийг Нийслэлийн Өмчийн харилцааны газрын Нийслэлийн төрийн сангийн 100200051024 тоот дансанд төвлөрүүлэхийг Нийслэлийн ерөнхий боловсролын 7 дугаар сургууль (Д.Дашдорж)-д, орлого төвлөрүүлэлтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Өмчийн харилцааны газар (В.Оюумаа)-т тус тус даалгасугай.

3.Энэ захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газар (Л.Хосбаяр)-т даалгасугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН
ЗАХИРАГЧ



Х.НЯМБААТАР



АКТАЛЖ, НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛЭЭС ХАСАХ БАРИЛГЫН ЖАГСААЛТ

Д/д	Барилга байгууламжийн нэр	Ашиглалтад орсон он	Байршил	Бүртгэлийн үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг /2024.05.30-ны байдлаар/	Акталж, данснаас хасах үндэслэл
1	Нийслэлийн ерөнхий боловсролын 7 дугаар сургуулийн хичээлийн А байр /хуучин барилга/	1972	Хан-Уул дүүрэг 16 дугаар хороо сургуулийн гудамж	186,423,325.79	73,826,935.38	112,596,390.41	Хотын стандарт, хяналтын газрын Барилгын техникийн хяналтын улсын байцаагчийн 2024 оны 02-13-01/026/30 тоот дүгнэлт
Нийт дүн				186,423,325.79	73,826,935.38	112,596,390.41	